



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2016 оны 02 сарын 02 өдөр

Дугаар А/112

Мандалговь

Төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 "а", Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Авлигатай тэмцэх газраас аймгийн 2015 оны авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг үнэлж ирүүлсэн зөвлөмж, иргэд, олон нийт, иргэний нийгмийн байгууллагуудын саналыг тусган боловсруулсан аймгийн Засаг даргын Тамгын газрын "Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2016 оны төлөвлөгөө"-г хавсралтаар баталсугай.

Хоёр. Төлөвлөгөөнд тусгагдсан ажил, арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулан хэрэгжүүлж, "Төрийн байгууллагаас авлигын эсрэг явуулж буй үйл ажиллагааг үнэлэх аргачлал"-ын дагуу тайлан, мэдээг гаргаж үнэлүүлэхийг аймгийн Засаг даргын тамгын даргын үүрэг гүйцэтгэгч /П.Бямбалхагва/-д үүрэг болгосугай.

Гурав. Төлөвлөгөөний холбогдох заалтуудыг хэрэгжүүлэн, авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр тусгайлан төсөв батлуулан зарцуулж, хэрэгжилтийг зохион байгуулж, байнгын хяналт тавьж, тайланг /нотлох баримт, бусад материалын хамт/ 11 дүгээр сарын 01-ний дотор аймгийн ЗДТГ-ын Хууль зүйн хэлтэст ирүүлэхийг сум, хэлтэс, агентлагийн дарга нарт үүрэг болгосугай.


ЗАСАГ ДАРГА



С.ОД-ЭРДЭНЭ

020000117

Аймгийн Засаг даргын 2016 оны 08 дугаар сарын 15 өдрийн 4/1...р захирамжийн хавсралт



ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН АВЛИГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2016 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хийх ажлын агуулга	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур		Хариуцах эзэн	Хүрэх үр дүн
			Хугацаа	Гүйцэтгэлийн үзүүлэлт		
Нэг: Хуулиар хүлээсэн үүргийн биелэлт						
1	Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, энэ талаархи мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцөлийг хангах.	Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр иргэдэд зориулсан хуулийн булан ажиллуулах. Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчилсан гарын авлага материалыг хэвлүүлж иргэдэд хүргүүлэх. АТГ-аас бэлтгэн ирүүлсэн сурталчилгааны материалыг иргэд, байгууллага, албан хаагчдад түгээх.	2-4 дүгээр улирал	Авлигын эсрэг хууль тогтоомжийг боломжит хэлбэрээр сурталчлах /мэдээллийн самбар, цахим хуудас, теле сурталчилгаа, яриа таниулга, сонсгол, нээлттэй өдөрлөг, хэлэлцүүлэг, хэвлэмэл материал г.м/ Авлигатай тэмцэх газраас бэлтгэн хүргүүлсэн сурталчилгааны материалыг иргэд, байгууллага, албан хаагчдад түгээх.	Аймгийн ЭДТГ-ын Хууль зүйн хэлтэс	Иргэд, олон нийт албан хаагчдын Авлигын эсрэг хуулийн мэдлэг нэмэгдсэн байна.
2	Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг ба нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг олон нийтэд танилцуулах, сонирхогч бүлгүүдтэй харилцан санал солилцох.	Хууль тогтоомж, дүрэм, журам шаардлагатай маягт болон зөвшөөрлийн бүртгэл бусад мэдээллийг байгууллагын цахим хуудсанд байршуулах. Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг, шийдвэрийн төслийг цахим хуудсанд байршуулж, иргэд олон нийтийн саналыг тусгах боломжийг бүрдүүлэх. Байгууллагын цахим хуудсанд зайлшгүй байх мэдээллийн жагсаалтын дагуу мэдээллийг бүрэн оруулж, тухай бүр шинэчлэх.	Тухай бүр	Боловсруулж байгаа хууль, Улсын Их Хурал, Засгийн газар, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төсөлд иргэд, олон нийт, сонирхогч бүлгийн санал, шүүмжлэлийг цахим хуудсаар хүлээн авах боломжийг бүрдүүлэх. Боловсруулж байгаа хууль, УИХ, Засгийн газар, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг цахим хуудсандаа байршуулсан байх. Дээрх асуудлаар иргэд, олон нийт, сонирхогч бүлгүүдтэй харилцан санал солилцсон байх.	АЗДТГ /нийт хэлтэс, тасаг, алба/	Олон нийтийн санал, санаачлагыг шийдвэрт тусгасан байна.

3	Төрийн хяналтын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах.	<p>Тухайн жилд явуулах хяналт шалгалтын ажлын төлөвлөгөө /төлөвлөгөөт/-г цахим хуудсандаа байршуулах.</p> <p>Хяналт шалгалтын дүнг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, мэдээллийн самбарт байршуулж, "Засаг даргын 21 хоногийн уулзалт"-аар иргэд, олон нийтэд мэдээлэх.</p> <p>Хяналт шалгалтын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, санал, зөвлөмж, үр дүнгийн талаар цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулж сурталчлах.</p>	Улирал бүр	<p>Хийсэн хяналт шалгалтынхаа дүнг олон нийтэд мэдээлсэн байх /цахим хуудсаар, хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлсэн байх/</p> <p>Хяналт шалгалтын мөрөөр авсан арга хэмжээ /дүгнэлт, акт, зөвлөмж гаргах, түүний мөрөөр холбогдох арга хэмжээг авсан байдал/-ний үр дүнгийн талаар мэдээлсэн байх.</p>	СТСХ СХАА МХГ ХШҮТ	Хяналт шалгалтын талаар мэдээллийн ил тод байдал хангагдсан байна.
4	Төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаад зээл, тусламж, түүний хуваарилалтыг олон нийтэд тухай бүр мэдээлэх /цахим хуудсаараа/	<p>Тухайн жилийн төсөв, өмнөх оны төсвийн гүйцэтгэл, сар, улирлын төсвийн гүйцэтгэл, хагас жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан, дараа жилийн төсвийн төсөл, жилийн эцсийн санхүүгийн тайланг хуульд заасан хугацаанд цахим хуудас болон мэдээллийн самбарт ойлгомжтой байдлаар байрлуулан иргэд, иргэний нийгмийн байгууллагын зүгээс төсвийн зарцуулалтад хяналт тавих боломжийг хангах.</p> <p>Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, тухайн жилийн төсөвт орсон өөрчлөлт, гадаадын зээл тусламжаар хэрэгжилт буй төсөл хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнг цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулж нээлттэй байлгах.</p> <p>Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгаан, төсөвт орсон нэмэлт, өөрчлөлтүүдийг тайлбарлаж, төсвийн орлого бүрдүүлэлтийг нээлттэй болгох</p>	Тухай бүр	<p>Тухайн жилийн төсөв /1 дүгээр сарын 10-ны дотор/</p> <p>Өмнөх оны төсвийн гүйцэтгэл /4 дүгээр сарын 1-ний дотор/</p> <p>Сарын төсвийн гүйцэтгэл /дараа сарын 8-ны дотор/</p> <p>Улирлын төсвийн гүйцэтгэл /дараа сарын 8-ны дотор/</p> <p>Хагас жилийн төсвийн гүйцэтгэл /8 дугаар сарын 15-ны дотор/</p> <p>Хагас жилийн санхүүгийн тайлан /8 дугаар сарын 15-ны дотор/</p> <p>Дараа жилийн төсвийн төсөл /9 дүгээр сарын 15-ны дотор/</p> <p>Жилийн эцсийн санхүүгийн тайлан /4 дүгээр сарын 25-ны дотор/</p> <p>Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт /4 дүгээр сарын 25-ны дотор/</p> <p>Аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ /7 дугаар сарын 1-ний дотор/</p> <p>Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар /улирал бүр/</p>	СТСХ ХБХ НДХ	Төсвийн ил тод байдал хангагдсан байна.

		<p>/татварын болон татварын бус орлогын талаарх мэдээлэл/</p> <p>Төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийн талаарх мэдээллийг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилах.</p> <p>Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийн жагсаалтыг тухайн этгээдийн эцэг /эх /-ийн нэр, өөрийн нэрийн хамт цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх.</p>	<p>Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт /өөрчлөлт орсноос хойш ажлын 7 хоногийн дотор/</p> <p>Төсвийн орлого бүрдүүлэлтийг нээлттэй болгох /татварын орлого, татварын бус орлогын талаарх мэдээлэл/</p> <p>Хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт /өөрчлөлт орсноос хойш 7 хоногийн дотор/</p> <p>Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт /гүйлгээ хийснээс хойш 7 хоногийн дотор/</p> <p>Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт /өөрчлөлт орсноос хойш 7 хоногийн дотор/</p> <p>Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр /батлагдсанаас хойш 7 хоногийн дотор/</p> <p>Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийн жагсаалт /тухайн этгээдийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэрийн хамт /-ыг цахим хуудсандаа байрлуулах.</p>		
5	<p>Чиг үүргийн дагуу олгож буй зөвшөөрөл, бүртгэлийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, олон нийтэд танилцах боломжоор хангах.</p>	<p>Иргэд, байгууллага, аж ахуйн нэгжид олгож буй тусгай зөвшөөрлийн бүртгэл, түүнийг олгоход бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, олгох журмыг ил тод нээлттэй болгох.</p> <p>Тухайн зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар</p>	<p>Жилийн турш</p> <p>Тухайн байгууллагаас олгож буй зөвшөөрөл /тусгай зөвшөөрөл, лиценз, эрх олгох г.м бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл/-ийн жагсаалтыг цахим хуудсандаа байршуулах</p> <p>Дээрх зөвшөөрөл олгоход шаардлагатай баримт бичгийн жагсаалт, уг асуудлыг шийдвэрлэх журмыг цахим</p>	ХБХ, НХХ	<p>Төлбөр хураамжтай холбоотой мэдээллийг иргэд, олон нийт авах боломжийг бүрдүүлсэн байна.</p>

		болгох хугацааг цахим хуудсанд ойлгомжтой байдлаар байршуулах.		хуудсандаа байршуулах. Тухайн зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байршуулах. Чиг үүргийн дагуу нууцад хамаарахаас бусад бүртгэлийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа ил тод болгох.		
6	Хүний нөөцийн ил тод байдлыг хангах, олон нийтийг түүнтэй танилцах боломжоор хангах.	Сул орон тооны болон нөөцөөс нөхөх зарыг цахим хуудсанд байршуулж, тухай бүр шинэчлэх. Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалт, удирдах ажилтны сонгон шалгаруулалтыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд тухай бүр мэдээлж зарлах.	Тухай бүр	Сул орон тооны зарыг цахим хуудсандаа байршуулах /тухай бүр шинэчилсэн/ Сонгон шалгаруулалт явуулах талаар олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарласан байх	ТАСЗ ТЗУХ	Сонгон шалгаруулалт болоод сул орон тооны талаарх мэдээлэл иргэдэд нээлттэй болсон байна.
7	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах, түүнтэй танилцах боломжоор хангах	Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөг иргэд, олон нийтэд цахим хуудсаар мэдээлэх. Төрийн худалдан авах ажиллагааны баримт бичиг, сонгон шалгаруулалтын журам, урилгыг цахим хуудсанд байршуулж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд сурталчлах. Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх мэдээллийг цахим хуудсанд байрлуулан шинэчлэх, шалгарсан болон шалгарч чадаагүй шалтгаан, нөхцөл, хуулийн үндэслэлийн талаар тодорхой танилцуулах. Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил	Жилдээ	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг цахим хуудсандаа байршуулах /1 дүгээр сарын 10-ны дотор/ Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам /тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт/, тендерийн урилгыг цахим хуудсандаа байршуулах байх. Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгааныг цахим хуудсанд байршуулах. Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр,	ХБХ ХААА	Оролцогч тэгш эрх эдлэх боломж бүрдэнэ. Иргэд, олон нийт энэ чиглэлийн мэдээллээр хангагдсан байна.

		<p>үйлчилгээний нэр, санхүүжилтын хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийг цахим хуудсанд байршуулах.</p> <p>Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт, шалгалтын дүнг цахим хуудсанд байршуулах.</p> <p>Тендерийн үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоод, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулсан байх.</p>		<p>санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийг цахим хуудсандаа байршуулах.</p> <p>Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт, шалгалтын дүнг цахим хуудсандаа байршуулах.</p> <p>Тендерийн үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоод, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулсан байх.</p>		
8	Албан хаагч бүрийн ажил үүргийн хуваарийг тодорхой болгох	<p>Төрийн албан хаагчдын ажил үүргийн чиглэлийг нэг бүрчлэн цахим хуудсаар нээлттэй болгож байршуулах.</p> <p>Төрийн албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг багаар хэлэлцэн, баталж мөрдүүлэх.</p>	Жилийн турш	<p>Төрийн албан хаагч нэг бүрийн ажил үүргийн хуваарь, ажлын байрны тодорхойлолтыг баталж мөрдүүлсэн байх.</p> <p>Хариуцсан ажил, үүргийн чиглэлийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа нээлттэй болгох.</p>	АЗДТГ /нийт хэлтэс, тасаг/	Мэдээлэл иргэд, олон нийтэд нээлттэй болсон байна.
9	Авлигатай тэмцэх зорилго бүхий төрийн бус байгууллага, иргэдийн сайн дурын хөдөлгөөнийг дэмжих, үйл ажиллагаандаа татан оролцуулах.	<p>Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага, сайн дурын хөдөлгөөнийг дэмжиж, хамтран ажиллах.</p> <p>Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт, явц болон АТГ-аас ТББ-аар гүйцэтгүүлсэн судалгааны дүнгийн талаарх мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр иргэд, олон нийтэд хүргэх.</p> <p>2015 онд "Иргэний нийгмийн байгууллага" ТББ-аар гүйцэтгүүлсэн Төрийн үйлчилгээний чанар хүртээмж судалгаа хийгдсэн сум, байгууллагуудад хүргүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтийг иргэд, олон</p>	2-4 дүгээр улирал	<p>Тодорхой төрлийн үйл ажиллагааны хэрэгжилт, явц байдалд хяналт тавих, судалгаа, дүн шинжилгээ хийх ажлыг иргэний нийгмийн байгууллагаар гүйцэтгүүлсэн байх /1 ба түүнээс дээш/</p> <p>Төрийн бус байгууллага, иргэдтэй хамтран хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүнгийн талаарх мэдээллийг тайландаа тусгасан байх.</p> <p>Хэрэгжүүлсэн ажил, хамтын ажиллагааны талаар хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим хуудсаараа мэдээлсэн байх.</p>	ХЗХ ТЗУХ, ИНБ-ын сүлжээний ТББ-ууд	Авлигын талаарх иргэд, олон нийтийн ойлголт, мэдлэг, мэдээлэл, оролцоо, хандлага сайжирна.

		нийтэд сурталчуулах ажлыг зохион байгуулах.				
10	Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хариуцан зохион байгуулах, уг асуудлаар Авлигатай тэмцэх газартай харилцах бүхий албан тушаалтантай байх.	Эрх бүхий албан тушаалтны ажлын байрны тодорхойлолт, үр дүнгийн гэрээнд гүйцэтгэх үүргийг тусган хэрэгжүүлэх.	Жилдээ	ЭБАТ-ны гүйцэтгэх чиг үүргийг ажлын байрны тодорхойлолт болон ажил үүргийн хуваарьт тусгасан байх.	АЗДТГ, ХЗХ	Сум, байгууллагын эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагаа сайжирсан байна.
		Эрх бүхий албан тушаалтныг АТГ-ын сургалтанд хамруулах.	Тухай бүр	Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан сургалтад хамрагдсан байх.		
		Эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагааг үнэлж АТГ-т хүргүүлэх.	3 дугаар сард			
		Сум, байгууллагын ЭБАТ-нуудад Авлигын болон ашиг сонирхлын зөрчлийн тухай хууль тогтоомж, мэдүүлгийн бүрдүүлэлт, мэдээллийн системийн ашиглалт, цахим бүрдүүлэлтийн талаар сургалт зохион байгуулах.	1 дүгээр сард	ЭБАТ-ны үйл ажиллагааг үнэлэх.		
11	Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн дүрмийг мөрдүүлэх.	Ёс зүйн дүрмийг боловсруулан баталж мөрдүүлэх.	1-р улиралд	Ёс зүйн дүрмийн төсөлд Авлигатай тэмцэх газраас өгсөн саналыг тусгасан байх	ХЗХ, ТЗУХ, ТАСЗ, Ёс зүйн хороо	Ашиг сонирхлын зөрчлийн талаарх мэдээлэл авах боломжийг бүрдүүлсэн байна.
		Зөрчлийн талаарх мэдээлэл хүлээн авах нөхцлийг бүрдүүлэх.		Ёс зүйн дүрмийг батлах, мөрдүүлэх /албан хаагчдад танилцуулсан байдал/		
		Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг, мэдэгдэл, хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд гаргуулах, олон нийтэд нээлттэй байлгах.		Зөрчлийн талаарх мэдээлэл хүлээн авах нөхцөл /тогтмол утас ажиллуулах, цахим хуудсанд байршуулах, шуудангаар, биечлэн, хайрцаг байршуулах г.м/-ийг бүрдүүлсэн байх.		
		Сум, байгууллагуудын удирдлагаас батлан гаргасан шийдвэрүүд авлига, хүнд суртал үүсэх боломж бүрдүүлсэн эсэхийг хянан үзэх, шаардлагатай тохиолдолд хүчингүй болгох, өөрчлөх саналыг холбогдох байгууллагад хүргүүлж шийдвэрлүүлэх.	Жилийн турш	Зөрчил үүссэн буюу үүсч болзошгүй тохиолдолд урьдчилан сэргийлэх арга хэмжээ /Зөвлөмж/-г авах.		
		Төрийн байгууллага, албан тушаалтны авлига гарах нөхцөл боломж		Зөрчил илэрсэн тохиолдолд хуульд заасан хариуцлагыг хүлээлгэсэн байх		
				Ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг		

		бүрдүүлсэн шийдвэрийг АТГ болон Хууль зүйн яаманд чиглэлийн дагуу дахин нягталж хууль тогтоомжид нийцүүлэх арга хэмжээ авах.		хамт олонд мэдээлсэн байх.		
12	Давхар ажил эрхлэх боломжтой эсэхийг шийдвэрлэх.	Сум, байгууллагуудаас давхар ажил эрхлэлтийн талаарх судалгааг шинэчлэн гаргуулж, нэгдсэн судалгаатай байх.	Жилдээ	Хууль болон Засгийн газраас зөвшөөрсөн давхар эрхэлж болох ажлын жагсаалтыг гаргаж албан хаагчдад танилцуулсан байх. Давхар ажил эрхлэлтийн талаарх судалгаатай байх, давхар ажил эрхлэх тохиолдолд зөвшөөрөл олгодог байх.	ХЗХ, ТЗУХ	Давхар ажил эрхлэхтэй холбоотой судалгааг гаргасан байна.
13	Байгууллагын удирдлагаас гаргаж буй шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах.	Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн, зохион байгуулалтын бүтцийг ил тод болгох. Аймгийн Засаг дарга, ЗДТГ-ын дарга нараас батлан гаргаж буй шийдвэр /захирамж, тушаал/-ийг ил тод нээлттэй байршуулж сурталчлах. Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам зааврыг нээлттэй болгох. Зөвхөн хууль тогтоомжид заасан төлбөр, хураамжийг үйлчлүүлэгчээс авч, түүний хэмжээг цахим хуудас болон мэдээллийн самбарт ойлгомжтой байдлаар байршуулах.	Тухай бүр	Удирдлагын шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах нөхцөл, боломжийг бүрдүүлсэн байх /цахим хуудсаар/ Удирдлагаас гаргасан төрийн болон байгууллагын нууцад хамааруулснаас бусад шийдвэр /тушаал, захирамж/-ийг цахим хуудсандаа байршуулах. Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж /хуульчилсан акт/, дүрэм, журам, зааврыг цахим хуудсандаа байршуулах. Үйлчлүүлэгчээс авч буй төлбөр, хураамжийг цахим хуудсандаа байршуулах.	АЗДТГ /нийт хэлтэс, тасаг/	Иргэд, олон нийт энэ төрлийн мэдээллээр хангагдсан байна.
14	Иргэдийн өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх шат дамжлагыг цөөрүүлэх, зөрчлийн талаарх мэдээллийг хүлээн авч	Гомдол, мэдээлэл хүлээн авах чиг үүргийг бүтцийн нэгж /ажилтанд/-д хариуцуулж, тухайн ажилтны овог, нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авах цагийн хуваарийг цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулах болон нийтэд бусад боломжит	Тухай бүр	Хууль тогтоомжоор тогтоосон өөрийн эрхлэх асуудлын хүрээг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж, сурталчилсан байх. Өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлт, мэдээлэл хүлээн авах нөхцөлийг бүрдүүлсэн байх /утас, хайрцаг, санал хүсэлтийн давтар, факс, цахим, бичгээр, амаар г.м	ТЗУХ, ХМОНХА	Төрийн үйлчилгээний чанар, шуурхай, хүртээмж ил тод байдал нэмэгдэнэ.

	шалгах.	хэлбэрээр мэдээлж сурталчлах. Иргэдийн санал, хүсэлт, гомдол, мэдээлэл хүлээн авах тусгай дугаарын утас ажиллуулах, цахим болон санал хүсэлтийн хайрцаг, бичгээр, мөн биечлэн хүлээн авах боломжийг бүрдүүлэх, бүртгэл хөтлөх. Иргэдийн санал, хүсэлт, гомдол, мэдээллийг шуурхай хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэх, хариуг албан ёсоор мэдэгдэх, шаардлагатай мэдээллийг цахим хуудсанд байршуулсан байна.		хэлбэрээр/ Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байршуулах. Иргэдийн өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлт, мэдээллийг шийдвэрлэсэн талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр тогтмол хугацаанд мэдээлсэн байх.		
15	Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах.	Эрсдэлтэй ажил, албан тушаал, үйлчилгээний жагсаалтыг гаргаж, уг ажил, үйлчилгээг гүйцэтгэх албан тушаалтан, ажилтны үйл ажиллагаа хууль тогтоомж, холбогдох дүрэм, журамд нийцэж буй эсэхэд хяналт тавих. Төрийн байгууллагын байранд түүний үйлчилгээг эрхэлдэгээс бусад аж ахуйн нэгж, байгууллагыг байрлуулахгүй байх. Нийтийн албан тушаалтнууд ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг гаргаж хэвшүүлэн, албан хаагчийн ажлын байрыг сэлгүүлэн ажиллуулахыг судлах.	Жилдээ	Авлигад өртөх эрсдэлтэй ажил, албан тушаал, үйлчилгээний жагсаалтыг гаргах, уг жагсаалтыг гаргахдаа тодорхой судалгаа, шинжилгээнд тулгуурласан байх. Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх /хүнд суртал, чирэгдлийг багасгах, сөрөг үзэгдлийг хаах, ашиг сонирхлын зөрчлийн мэдүүлгийг хянах, мэдэгдэл гаргах, албан хаагчийн ажлын байрыг сэлгүүлэх зэрэг үр дүнтэй арга хэмжээг хэрхэн зохион байгуулсан г.м/	Аймгийн ЗДТГ /нийт хэлтэс, тасаг/	Авлига үүсэхэд нөлөөлж байгаа шалтгаан, нөхцлийг арилгах боломж бүрдэнэ.
16	Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрийг биелүүлэх.	Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн зөвлөмжүүдийн биелэлтийг заалт бүрээр тооцон гаргаж хүргүүлэх. АТГ-аас зөрчил арилгуулах болон хариуцлага тооцохоор ирүүлсэн албан бичгийн биелэлтийг тооцож	Тухай бүр	Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн Зөвлөмжийн биелэлт, зохион байгуулсан арга хэмжээ АТГ-ын мөрдөн байцаагчаас гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгуулахаар хүргүүлсэн мэдэгдлийн биелэлт, зохион байгуулсан арга хэмжээ	Аймгийн ЗДТГ /нийт хэлтэс, тасаг/	Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн шийдвэрийн биелэлт хангагдана.

		хариуг хүргүүлсэн байх.		АТГ-аас зөрчил арилгуулахаар хүргүүлсэн албан бичгийн биелэлт, зохион байгуулсан арга хэмжээ		
		АТГ-ын даргын 2012 оны 74 дүгээр тушаалаар батлагдсан журмыг хэрэгжүүлж ажиллах.		АТГ-аас хариуцлага тооцож, арга хэмжээ авахуулахаар хүргүүлсэн албан бичгийн биелэлт Авлига гарах нөхцөл боломжийг бүрдүүлсэн гэж үзсэн дүрэм, журам, заавар, шийдвэрийг өөрчлөх буюу хүчингүй болгосон эсэх. АТГ-ын даргын 2012 оны 74 дүгээр тушаалаар батлагдсан "Албан тушаалтан өөрт ногдуулсан сажилгын шийтгэлийн талаарх мэдээллийг холбогдох этгээд болон нийтэд өөрийн зардлаар хүргэх арга хэмжээний журам"-ыг хэрэгжүүлэх чиглэлээр авсан арга хэмжээ		
Хоёр. Авлигатай тэмцэх санал, санаачилга						
17	Авлигын эсрэг соён гэгээрүүлэх, авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх.	Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг иргэд, олон нийтээс санал авч, үнэлэх аргачлалын дагуу боловсруулан, АТГ-аар хянуулж, Засаг даргын захирамжаар батлуулах .	1 дүгээр сард	Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө баталж, хэрэгжүүлсэн байх. Төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээ цаг, хугацаандаа хэрэгжсэн байх.	Хууль зүйн хэлтэс	Авлигын эсрэг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа бодитой үнэлэгдэнэ.
		Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг аймгийн хэмжээнд нэгтгэн /нотлох баримт/ АТГ-т хүргүүлэх.	11 дүгээр сард	Хэрэгжилтийн тайланг тогтсон хугацаа /жил бүрийн 11 сарын 15-ны дотор/-нд АТГ-т хүргүүлсэн байх. Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд гарч буй хүндрэл бэрхшээл, ололт амжилт, хүрсэн үр дүн, цаашид хэрэгжүүлэх ажлын саналыг тайланд тусгасан байх.		
		Төлөвлөгөөг хэрэгжүүлэх явцад гарч буй бэрхшээл, үр дүн, цаашид хэрэгжүүлэх ажлын саналыг тайланд тусгах.				
18	Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлэл, хүчин чармайлт	Авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх чиглэлээр /зорилго бүхий/ төрийн бус байгууллагаас ирүүлсэн бүтээлч, ажил хэрэгч санал, төслийг дэмжин ажиллана.	2 дугаар улир-лаас	Авлигын эсрэг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаас гаргасан санал, санаачилга /уриа, уриалга, мэдэгдэл, амлалт г.м/-д нэгдсэн байдал Удирдах алба тушаалтнуудын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлэл, хүчин чармайлт.		Төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагаа улам сайжирна.

		Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны зарим ажил үйлчилгээг ТББ-аар гүйцэтгүүлэх хөрөнгийг шийдвэрлэнэ.	санаачилга, тэдний үлгэр жишээ байдал Авлигын эсрэг арга хэмжээнд зориулан тусгайлан хөрөнгө гаргасан эсэх /зарцуулалт/ Удирдлагын хүсэлт, эрмэлзлэл, хүчин чармайлт, үлгэр жишээ байдлын талаар ажилтнуудаас өгсөн үнэлгээ		
19	Албан хаагчдын шударга байдал ба түүнийг нэмэгдүүлэх	ХААА-ны цахим тендер, Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалт, удирдах ажилтны сонгон шалгаруулалтыг зохион байгуулахад иргэдийн оролцоо, ил тод байдлыг хангах. Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг эрчимжүүлэх чиглэлээр ажлын хэсгийн гишүүдийг хуваарилан улирал бүр хуралдуулж явц байдлыг мэдээлэх. Байгууллагын дотоод аудит, хяналт шалгалтын хүрээнд илрүүлсэн зөрчлийг ил тод нээлттэй болгох.	Тухай бүр Албан тушаалтан, албан хаагчдын шударга байдлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ /шударга ёс, ёс зүй, сонирхлын зөрчлийн талаарх сургалт, хэлэлцүүлэг, ярилцлага, өдөрлөг, зөвлөмж өгөх г.м/-г авах. Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр авсан арга хэмжээ Байгууллагын дотоод аудит, хяналт шалгалтын хүрээнд илрүүлсэн авлигын зөрчил, авсан арга хэмжээ Бусад байгууллага, иргэдийн гомдлоор илэрсэн зөрчил, авсан арга хэмжээ Авлигатай тэмцэх газрын шалгалтаар илэрсэн авлигын гэмт хэрэг /шүүхээр шийдвэрлэгдсэн/ ба бусад зөрчил	Аймгийн ЗДТГ /нийт хэлтэс, тасаг/	Иргэд олон нийтийн энэ талаарх мэдлэг нэмэгдэнэ.

ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

2016.01.26